



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/572

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн "Аймгийн 2025 оны төсвийг тодотгон батлах тухай" 39 дүгээр тогтоол, Үнэлгээний хорооны 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 830 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААХААГ/20250202134 дугаартай Жаргалан сумын Бүрэн багт өндөр үр ашигтай хээлтүүлэгч худалдан авах ажлыг "Гүнэбулаг" ХХК-тай гэрээ байгуулан худалдан авах ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Очир)-т олгосугай.

2.Ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг боловсруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Очир)-т үүрэг болгосугай.

3.Ажлын чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

